


АМГАЛАН ДУЛААНЫ  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



М.МӨНХӨӨ



БАТЛАВ  
БУКА ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ  
С.ГАНСҮХ

**ЗУУХ №3 ХАЛАХ ГАДАРГУУГ ХЭСЭГЧЛЭН СОЛИХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

Дугаар № 2023/46

2023 оны 06 р сарын 08

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Амгалан дулааны станц ТӨХК –ийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө /цаашид захиалагч гэх/ нөгөө талаас “Бука” ХХК-ийн захирал С.Гансүх /цаашид гүйцэтгэгч гэх/ хамтад нь/ цаашид талууд гэх / нар нь Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3 дах заалт, 34 дүгээр зүйлийн 34.1.5 дах заалт, Амгалан дулааны станц ТӨХК-ийн үнэлгээний хорооны 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн №02 тоот хурлын шийдвэр, зөвлөмж, 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

**Нэг. Гэрээний зорилго**

1.1 Гэрээний зорилго нь “Зуух №3 халах гадаргууг хэсэгчлэн солих” засварын ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж захиалагч талд графикт хугацаанд технологийн дагуу чанартай хийж гүйцэтгэн зуухны хэвийн үйл ажиллагааг хангаж хүлээлгэж өгөх, Захиалагч, гүйцэтгэгч талуудын үүрэг, хариуцлагыг тогтоох, төлбөр тооцоог гэрээнд заасан хугацаанд хийх, ажил эхлэх, гүйцэтгэх, дуусах явцтай холбоотой үүссэн харилцааг зохицуулахад оршино.

**Хоёр. Гэрээний нөхцөл, хугацаа, баталгаа**

- 2.1 Гүйцэтгэгч нь “Зуух №3 халах гадаргууг хэсэгчлэн солих” (цаашид “ажил” гэх) -ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтад заагдсан ажлын эзлэхүүнээр, техникийн тодорхойлолт, графикт заасан хуваарийн дагуу, шаардлага хангасан бараа, материалаар гэрээний үнэд багтаан 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдөр дуусгах ба хуанлийн 69 хоногт багтаан хийж гүйцэтгэнэ. Компанийн горим ажиллагаатай холбоотойгоор эхлэх өдрийг мөрдөх боломжгүй болсон бол наряд нээгдсэн өдрөөр тооцож болно.
- 2.2 Зуух №3 халах гадаргууг хэсэгчлэн солих ажлын баталгаат хугацаа гэрээт ажлыг хүлээлгэн өгч, гэрээ дүгнэсэн акт баталгаажсан өдрөөс хойш 12 / арван хоёр/ сар байна.
- 2.3 Гүйцэтгэгч нь гэрээт ажлын баталгаат хугацаанд гэрээний нийт үнийн дүнгийн 5%-тай тэнцэх төлбөрийг захиалагчийн дансанд чанарын баталгаа болгон үлдээнэ.

Захиалагч тал

1/7

Гүйцэтгэгч тал

- 2.4 Баталгаат хугацаанд тухайн тоноглолд гэмтэл саатал гарвал захиалагчийн мэдэгдэл, шаардлагын дагуу цаг хугацаанд нь гүйцэтгэгч тал үнэ төлбөргүй чанартай хийж гүйцэтгэн захиалагчид хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 2.5 Талууд үнийн санал, 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хэлэлцээрээр ажил гүйцэтгэх хугацаа, төлбөрийн нөхцөл, чанарын баталгаа болон бусад нөхцөлүүдийг харилцан тохиролцсон.

### Гурав. Төлбөр тооцоо

- 3.1 Гэрээт ажлын үнэ нь 709,400,000 /Долоон зуун есөн сая дөрвөн зуун мянга/-н төгрөг байхаар талууд харилцан тохиролцов. Гэрээний үнэд материал, ажлын хөлс, тээвэр, даатгал, гааль, НӨАТ болон бусад зардлууд бүгд багтсан болно.
- 3.2 Санхүүжилтийг гэрээний баталгаажсан гүйцэтгэлээр хуваарийн дагуу гүйцэтгэгчийн дансанд шилжүүлнэ.


д/д	Төлбөрийн хэлбэр	Гэрээгээр тохирсон үнийн дүнгийн %-иар	Гэрээгээр тохирсон үнийн дүнгээс төгрөг мян.	Төлбөр хийх хугацаа
1	Гэрээ байгуулагдсанаас хойш ажлын 7 хоногийн дотор	20%	141,880,000	Нэхэмжлэх ирүүлснээс хойш ажлын 7 хоногийн дотор
2	Гэрээт засварын ажлын гэрээний гүйцэтгэл 30%-д хүрсэн үед	25%	177,350,000	Нэхэмжлэх ирүүлснээс хойш 30 хоногийн дотор
3	Гэрээт засварын ажлын гэрээний гүйцэтгэл 70%-д хүрсэн үед	25%	177,350,000	Нэхэмжлэх ирүүлснээс хойш 30 хоногийн дотор
4	Гэрээт засварын ажлын гэрээний гүйцэтгэл 100%-д хүрсэн үед	25%	177,350,000	Нэхэмжлэх ирүүлснээс хойш 30 хоногийн дотор
5	Хүлээлгэн өгснөөс хойш гэмтэл саатал гараагүй тохиолдолд 12 сарын дараа	5%	35,470,000	Нэхэмжлэх ирүүлснээс хойш 30 хоногийн дотор
6	Нийт дүн	709,400,000 /Долоон зуун есөн сая дөрвөн зуун мянган төгрөг/		

Захиалагч тал



2/7

Гүйцэтгэгч тал



- 3.3 Гэрээт ажлын үнийн дүнгийн 20 /хорь/-н хувь болох 141,880,000 /Нэг зуун дөчин нэг сая найман зуун наян мянга/-н төгрөгийг гэрээ баталгаажсанаас хойш ажлын 7/долоо/ хоногийн дотор гүйцэтгэгчийн Худалдаа хөгжлийн банкны 495052737 тоот дансанд шилжүүлнэ. Үлдэгдэл төлбөрийг ажлын гүйцэтгэлээр 3 /гурав/ хуваан нэхэмжлэлийн дагуу гүйцэтгэгчийн Худалдаа хөгжлийн банкны 495052737 тоот дансанд шилжүүлнэ.
- 3.4 Захиалагч нь гэрээний үнийн дүнгийн 5% болох 35,470,000 /гучин таван сая дөрвөн зуун далан мянга/-н төгрөгийг чанарын баталгаат хугацаанд дансандаа авч үлдэнэ.
- 3.5 Төлбөр тооцоотой холбогдолтой үйл ажиллагаа нь зөвхөн албан бичиг, шилжүүлгээр зохицуулагдана.

### Дөрөв. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 4.1 Гэрээт ажлыг батлагдсан техникийн тодорхойлолт, ажлын эзлэхүүний дагуу, графикт хугацаанд багтаан техникийн үзүүлэлтүүдийн хэвийн үйл ажиллагааг хангуулж цаашдын найдвартай ажиллагааг бүрэн хангаж, чанартай хийж гүйцэтгэнэ.
- 4.2 Ажлын эзлэхүүнд заагдсан ажлуудыг заавал бүрэн хийж гүйцэтгэнэ.
- 4.3 Баталгаат хугацаанд гүйцэтгэгчийн нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн ажлын чанараас шалтгаалан тоног төхөөрөмжид гэмтэл, саатал, доголдол гарсан нь засварын чанар муугаас болсон нь актаар тогтоогдвол гүйцэтгэгч тал үнэ төлбөргүйгээр заасан хугацаанд засварлаж хүлээлгэн өгнө.
- 4.4 Гэмтлийн актыг хоёр талын хамтарсан комисс тогтоож, хохирлын хэмжээг гаргана. .
- 4.5 Гэрээт ажлыг гүйцэтгэхдээ ажилтнуудынхаа хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, нэг бүрийн хувийн хамгаалах хэрэгслээр бүрэн хангаж, ХАБЭА-н болон галын аюулаас урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг авч ажиллах ба эдгээр шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн шаардлагаар ажлыг зогсооно.
- 4.6 Ажил гүйцэтгэх хугацаанд өөрийн ажилтнуудын нийгмийн болон эрүүл ахуйн асуудлыг бүрэн хариуцах бөгөөд Эрчим хүчний системд мөрдөгдөж буй ГАУСД, ТАД, ААД болон захиалагч талын хөдөлмөрийн дотоод журам, холбогдох хууль, бусад дүрэм журмыг мөрдөн осол, аварггүй, зөрчил гаргахгүй ажиллаж, өөрийн компанийн ажиллагсдын буруугаас үүдэн гарсан зөрчил доголдол, хохирлыг бүрэн хариуцан ажиллана. Захиалагчийн тавьсан хууль ёсны шаардлага зөвлөмжийг заавал биелүүлнэ. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэсний дараа доорх баримт бичгийг бүрдүүлнэ.

Үүнд:


Ажил гүйцэтгэсэн тайлан	4хувь
Экран хоолойн гагнуурын ажлын туршилт, шинжилгээг хийлгэсэн дүгнэлт	4хувь
Ажил хүлээлгэн өгсөн акт	4 хувь
Гэрээ дүгнэсэн протокол, акт	4хувь
Хуучин сэлбэг, материал тушаасан баримт	4хувь
Тухайн ажилтай холбоотой бусад акт баримтууд	4хувь

Захиалагч тал



3/7

Гүйцэтгэгч тал



Засварын өмнөх, засварын үеийн, засварын дараах,  
байдлыг фото зургаар баримтжуулан тайланд хавсаргана 4хувь  
Засвараас гарсан хог хаягдлыг зөвшөөрөгдсөн хогийн цэгт хаясан баримт 4 хувь

- 4.7 Ажил гүйцэтгэхэд шаардлагатай бараа материал, автомашин, техник, багаж, тоног төхөөрөмжийг станцын хашаанд оруулах үед тоо хэмжээг харуул хамгаалалтын ажилтанд бүртгүүлэн эрх бүхий албан тушаалтнуудын зөвшөөрөл, хяналтаар нэвтрүүлнэ.
- 4.8 Гүйцэтгэгч тал захиалагчийн зөвшөөрөлгүйгээр гэрээний эрх үүрэг, хариуцлагыг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй.
- 4.9 Ажил гүйцэтгэгч компани нь уг ажлыг гүйцэтгэх явцад нарядын системийг чанд мөрдөнө.
- 4.10 Ажил үйлчилгээг нэгэнт эхэлснээс хойш шалтгаангүйгээр гэрээг цуцлах санал тавихгүй
- 4.11 Гүйцэтгэгч гэрээ байгуулагдсаны дараа гэрээгээр ажиллах бүх ажилтнуудад урьдчилсан зааварчилгаа өгөгдсөний дараа станцын хашаанд ажилтнууддаа нэвтрэх түр үнэмлэх авна. Захиалагчийн дотоод дүрэм, журам, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм журмыг мөрдөн ажиллана.
- 4.12 Захиалагч талын зөвшөөрлөөр шаардлагатай үед илүү цагаар ажиллаж болно.
- 4.13 Гүйцэтгэгч нь гэрээнд заагдсан бараа, материалыг захиалагчтай зөвшилцөн захиалж, актаар хүлээлцэнэ. Барааг засварын ажлын явц, графикт хугацаанд нөлөөлөхгүй бүрэн нийлүүлнэ.
- 4.14 Гүйцэтгэгч нь засварын ажлын хугацаанд тоноглолын бүрэн бүтэн байдлыг бүрэн хариуцна.
- 4.15 Эcran хоолойн гагнуурын ажлын туршилт, шинжилгээг мэргэжлийн байгууллагаар заавал гүйцэтгүүлж, дүгнэлт гаргуулна.
- 4.16 Гүйцэтгэгч компанийн ажилтнууд нь бүгд мэргэжлийн үнэмлэхтэй дадлага туршлагатай, мэргэшсэн байна. ХАБЭА-н орон тооны ажилтанг заавал томилон ажиллуулах.
- 4.17 Засвар дууссаны дараа зуухыг усан шахалт хийж 72 цаг явуулж ажил хүлээн авах комисст хүлээлгэн өгөх ба энэ хугацаанд илэрсэн гэмтлийг бүрэн засаж сайжруулсны үндсэн дээр эцсийн байдлаар тоноглолыг актаар хүлээлгэн өгнө.
- 4.18 Гүйцэтгэлийн санхүүжилт хүлээгдсэнээс шалтгаалж засварын ажлыг зогсоохгүй ажиллана.

#### **Тав. Захиалагчийн эрх, үүрэг**

- 5.1 Галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, ХАБ, ААД-ийн шаардлагыг биелүүлэхээс татгалзсан эсэргүүцсэн, дүрэм стандартыг зөрчсөн чанарын гологдол гаргасан тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээг авах эрхтэй.
- 5.2 Баталгаат хугацаанд Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажлын чанартай холбоотой гэмтэл, доголдол гарвал дахин үнэ төлбөргүй хийж гүйцэтгэхийг шаардах эрхтэй.
- 5.3 Гүйцэтгэсэн ажлыг хугацаанд нь ажлын комисс хүлээн авч гэрээг дүгнэнэ.
- 5.4 Ажил гүйцэтгэх явцад гүйцэтгэгчийн ажилд захиалагч талаас хяналтыг тогтмол тавьж ажиллана.

Захиалагч тал



4/7

Гүйцэтгэгч тал



5.5 Захиалагч талаас гэрээний үнийн дүнг өөрчлөхгүйгээр зарим нэгэн ажил, ажлын тоо хэмжээнд гүйцэтгэгчтэй тохиролцсоны үндсэн дээр өөрчлөлт оруулж болно.

### **Зургаа. Талуудын хүлээх үүрэг хариуцлага**

- 6.1 Гүйцэтгэгчийн буруугаас засварын ажлын хугацааг хожимдуулснаас тоноглолын засварын хугацааг сунгаснаас үүдэн гарсан хохирлыг гүйцэтгэгч нь захиалагчийн өмнө бүрэн хариуцна.
- 6.2 Гүйцэтгэгч нь засварын ажлыг батлагдсан графикт хугацаанаас хэтрүүлбэл талууд харилцан тохиролцож гэрээний хугацааг сунгаж гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулснаас бусад тохиолдолд хугацаа хэтэрсэн гүйцэтгээгүй ажил үүргийн үнийн дүнгийн 0,1 %-иар хоног тутамд гүйцэтгэгч алданги хүлээх ба уг алданги нь гэрээний үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна. Алданги тооцож эхэлсэн тухайгаа гүйцэтгэгч талд бичгээр мэдэгдэнэ.
- 6.3 Захиалагчийн буруугаас төлбөр төлөх хугацаа хэтэрвэл гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,1 % -иар хоног тутамд захиалагч алданги хүлээх ба уг алданги нь гэрээний үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.
- 6.4 Баталгаат хугацааны дотор гүйцэтгэсэн ажлын чанар, техникийн гологдол, эвдрэл, гэмтэл гарвал захиалагч нь мэдсэн өдрөөс хойш гүйцэтгэгчид мэдэгдэж гүйцэтгэгч нь ажлын 5 хоногийн дотор өөрсдийн хөрөнгөөр үнэ хөлсгүй засварлаж хэвийн ажиллагаанд оруулж хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 6.5 Компанийн дотоод дүрэм, журам зөрчих, ажлын байранд ёс бус үйл ажиллагаа явуулах согтууруулах ундаа авчирсан, уусан тохиолдолд ажил гүйцэтгэх гэрээг цуцлах ба гүйцэтгэсэн ажлын хөлсийг төлөхөөс татгалзана.
- 6.6 Алданги төлсөн нь үндсэн үүрэг болон учирсан хохирлыг төлөх үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.
- 6.7 Захиалагчийн саналаар засварын явцад гарсан хүндрэл, ажлын эзлэхүүнд тусгагдаагүй нэмэлт ажлыг хоёр талын эрх бүхий албан тушаалтнууд шийдвэр гаргаж гэрээний үнэд багтаан хийж гүйцэтгэж болно.
- 6.8 Уг ажлын чанарын баталгаат хугацаа нь ажил хүлээлгэн өгч гэрээ дүгнэгдсэн өдрөөс хойш 12 сар байх бөгөөд баталгаат хугацаанд гарсан гэмтэл доголдлыг цаг хугацаа алдалгүй үнэ төлбөргүй шуурхай засварлаж өгнө.
- 6.9 Захиалагчийг төлөөлж гэрээний үүргийн биелэлт, ажлын гүйцэтгэлтэй холбоотой асуудлыг “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн Зуухан цехийн дарга Э.Ариунболд хариуцан ажиллана. Утас-99727172. Зуухны засварын ажилд хяналтыг Зуухан цехийн засварын инженер С.Түвшинбат хариуцан ажиллана. Утас-99058948.
- 6.10 Нийлүүлэгчийг төлөөлж гэрээний үүргийн биелэлт, ажлын гүйцэтгэлтэй холбоотой асуудлыг “Бука” ХХК-ийн мастер Х.Бат-Өлзий хариуцан ажиллана. Утас-80804675.


### **Долоо. Давагдашгүй хүчин зүйл**

Захиалагч тал



5/7

Гүйцэтгэгч тал



- 7.1 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх, газар хөдлөх, тахал болон байгалийн бусад хүчин зүйлс мөн цэрэг дайны үйл ажиллагаа төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт импортын хориг ажил хаялт үйлдвэрлэгчийн бүх төрлийн сул зогсолт зэрэг энэ гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгохыг ойлгоно.
- 7.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээ биелэгдэх боломжгүй болсон бол талууд бие биедээ нэн даруй мэдэгдэх ба гэрээний хугацаа дээрх нөхцөл байдал арилгах хүртэл хугацаагаар сунгагдах буюу нэг талын санаачилгаар цуцална.
- 7.3 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлыг зохиомлоор буюу болгоомжгүйгээр бий болгосноос бусад тохиолдолд учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд чөлөөлөгдөнө.
- 7.4 Давагдашгүй хүчин зүйл гэдгийг зөвхөн Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим батална.

### **Найм. Гэрээг цуцлах, нэмэлт өөрчлөлт оруулах**

- 8.1 Энэхүү гэрээнд заасан үүргээ талууд ноцтой зөрчсөн буюу хууль, гэрээнд заасан үндэслэл бий болсон бол талууд хэдийд ч гэрээг цуцлах эрхтэй.
- 8.2 Хэрвээ талууд гэрээний хугацаа сунгах, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарвал талууд албан бичгээр урьдчилан мэдэгдэн хоёр тал тохиролцож, гэрээний хугацаанд зөвхөн нэг удаа нэмэлт өөрчлөлт оруулж гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар гэрээний нэгэн адил хууль зүйн хүчинтэй.
- 8.3 Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх хугацаа хожимдуулсан, цаашид уг ажлыг үргэлжлүүлэх боломжгүй болсон тохиолдолд захиалагчийн санаачилгаар гэрээг цуцалж чанарын баталгааг буцаан олгохгүй.
- 8.4 Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг цаашид үргэлжлүүлэх боломжгүй болбол захиалагчид урьдчилан бичгээр 14 /арван дөрөв/ хоногийн өмнө мэдэгдэж харилцан тохиролцож зохих шийдвэр гаргасны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах буюу талууд гэрээг дуусгавар болгоно.

### **Ес. Бусад зүйл**

- 9.1 Энэхүү гэрээний үйлчлэл нь талууд гарын үсэг зурж тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж, талууд тус тусын үүргээ биелүүлж баталгаат хугацаа дууссанаар дуусгавар болно.
- 9.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3 Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэж Захиалагч 3 хувийг Гүйцэтгэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4 Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд сунгаж болно.

Захиалагч тал



6/7

Гүйцэтгэгч тал



9.5 Энэхүү гэрээг хэрэгжүүлэх болон хүчин төгөлдөр байх хугацаанд гарч болох бүх маргаан зөрчил зэргийг харилцан тохиролцож шийдэх ба үл тохиролцсон тохиолдолд Монгол Улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Энэхүү гэрээ нь үндсэн гэрээ хуудас, хавсралт хуудас, нийт хуудаснаас бүрдэнэ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН  
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР  Э.МӨНХЖАРГАЛ

СЭЭХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ  
НЯГТЛАН БОДОГЧ  Ө.УДВАЛ

АЖ АХУЙ, ХАНГАМЖИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА  Г.БАТТУЛГА

ЗУУХАН ЦЕХИЙН ДАРГА  Э.АРИУНБОЛД

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН  Г.САРУУЛ

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН:

ХАНГАМЖИЙН  
МЭРГЭЖИЛТЭН  Ш.ГАНТУЛГА

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

БУКА ХХК-ИЙН  
ИНЖЕНЕР  Х.БАТ-ӨЛЗИЙ

Хаяг: Монгол улс, Улаанбаатар  
хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1  
Утасны дугаар: 77111251, РД:6021646

Хаяг: УБ хот ХУД 24-р хороо 23-2003 тоот  
Утас: 99094171, 366861  
РД: 2884321.

Захиалагч тал



7/7

Гүйцэтгэгч тал

